



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreatkhural@parliament.mn  
http://www.parliament.mn

2012.12.30 № 49

Асуулга тавих тухай

Монгол Улс 1997 онд Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-д гишүүнээр элссэн бөгөөд Монгол Улсын Их Хурлаас ДХБ-д элссэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай тогтоол гаргаж байсан. Тус байгууллага нь олон улсын худалдаа, зах зээлийг либералчлахад чиглэсэн олон талт хэлэлцээ явуулах, худалдаанд мөрдөх дүрэм, журмыг тогтоох, ДХБ-ын олон талт хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, гишүүн орнуудын худалдааны бодлогыг хянах, худалдаанд тулгарч буй саад тотгорыг бууруулах чиглэлээр ажилладаг. Хоёр хөрш улс болох Бүгд Найрамдах Хятад Ард Улс 2008 онд, Оросын Холбооны Улс 2012 онд уг байгууллагад тус тус элссэн билээ.

Монгол Улс БНХАУ-тай автотээврийн хэлэлцээрийг 2011 онд, төмөр замын дамжин өнгөрөх тээврийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийг, мөн Монгол Улс Хятад Улсын нутаг дэвсгэрээр далайд гарах болон буцах, дамжин өнгөрөх тээвэр хийх тухай хэлэлцээрийг 2014 онд, ОХУ-тай Монгол Улс ОХУ-ын нутгаар дамжин тээвэр хийж, далайд гарах тухай хэлэлцээрийг 1992 онд, Олон улсын авто тээврийн харилцааны тухай хэлэлцээрийг 1996 онд, төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцөлийн тухай хэлэлцээрийг 2018 онд тус тус байгуулсан.

Түүнчлэн хоёр хөрштэй "Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр боловсруулах тухай гурван улс хоорондын санамж бичиг"-ийг 2015 онд, "Азийн авто замын сүлжээгээр олон улсын авто тээвэр гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг 2016 онд байгуулсан билээ.

Монгол Улс дээрх хоёр болон гурван талт хэлэлцээрийг байгуулсан төдийгүй гурван улс ДХБ-ын гишүүн хэдий ч манай улсаас экспортолж буй бараа, бүтээгдэхүүнд хөрш улсаас ногдуулж буй тариф, татварын хувь хэмжээний талаар Монгол Улсын бизнес эрхлэгчид, олон нийтийн дунд дутмаг ойлголттой байна. Мөн манай улсаас гаралтай бараа, бүтээгдэхүүн эдгээр улсын зах зээлд гарч өрсөлдөж чадахгүй байгаа шалтгааны талаар дорвитой мэдээлэл, судалгаа хомс байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, мөн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.1-д заасны дагуу УИХ-ын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуулгыг Танд хандан тавьж байна. Үүнд:

2021000218

1.Монгол Улсаас Оросын Холбооны Улсад экспортолж буй гол нэрийн бараа бүтээгдэхүүнд ногдуулж буй импортын татвар, НӨАТ, онцгой албан татвар, хураамж, тоон хязгаарлалтын талаар;

2.Монгол Улсаас экспортолж буй гол нэрийн бараа бүтээгдэхүүний тээврийн гаалийн тарифыг дээр дурдсан болон бусад олон улсын гэрээгээр хэрхэн зохицуулсан, тухайлбал, ДХБ-ын хэлэлцээрүүдийн хүрээнд олгож буй хөнгөлөлт, Монгол Улсад олгогдож буй давуу тал, тулгарч буй бэрхшээл сорилтын талаар;

3.Монгол Улсын гол нэрийн бараа бүтээгдэхүүнийг гуравдагч зах зээлд экспортлохоор ОХУ ба БНХАУ-ын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэхэд төмөр замын тарифын хэлэлцээр хэрэгжихгүй байгаагийн гол учир шалтгаан юу байна вэ? Тээврийн тариф болон тарифын бус саад тотгор, дээр дурдсан хэлэлцээр буюу тохиролцоо хэрэгжиж байгаа эсэх, хүндрэл бэрхшээлийн шалтгаан дээрх хэлэлцээрээс үүдэлтэй эсэх талаар;

4.Монгол Улс, БНХАУ, ОХУ нь ДХБ-ын гишүүний хувьд манай улсын экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүнийг хөрш улсад экспортлоход ДХБ-ын хүрээнд тарифын болон тарифын бус ямар хөнгөлөлт эдэлж, манай улс ямар үүрэг хүлээдэг талаар;

5.Дотоодын үйлдвэрийн импортыг орлох бүтээгдэхүүнийг импортын ижил төрлийн бүтээгдэхүүнтэй өрсөлдөхөд үзүүлж буй дэмжлэг, энэ чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар;

6.Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр Монгол Улсын хоёр болон олон талт гэрээний хэрэгжилтийн өнөөгийн байдал, тэдгээрийн Монгол Улсын эдийн засагт үзүүлж буй зэрэг нөлөө, давуу болон сул тал, хэрэгжүүлэх явцад тулгарч буй саад бэрхшээл, түүнийг даван туулахад худалдаа, тээврийг хөнгөвчлөх талаар ямар арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай талаар;

7.Дамжин өнгөрөх тээврийн болон тарифын хөнгөлөлтийн талаарх нийт хэлэлцээр, тохиролцоо, мөн ДХБ-д элссэнтэй холбогдуулан Засгийн газрын дамжин өнгөрөх тээврийн талаар хүлээсэн үүрэг, тэдгээрийн хэрэгжилтийн талаар;

8.Цаашид Монгол Улсын бараа, бүтээгдэхүүнийг ОХУ, БНХАУ-д экспортлох боломжийг нэмэгдүүлэх, Ази, Европыг холбосон газар зүйн байршлын давуу талаа ашиглан "Транзит Монгол" болох, гурван улс эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлж хамтдаа хожиж, хамтдаа хөгжихөд онцгой ач холбогдолтой БНХАУ-ын Эрзэнээс Сайхан тал, ОХУ-ын Хиагтаас Улаан-Үд-Эрхүү хүртэлх төмөр замын суурь бүтцийг өргөтгөх чиглэлээр улс төр, эдийн засгийн ямар яриа хэлэлцээ өрнүүлж буй талаар зэрэг болно.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.3-т заасан хугацаанд ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН




С.БЯМБАЦОГТ

Т.АУБАКИР

2021000218




Ш.АДЬШАА



Н.ГАНИБАЛ



Н.НАРАНБААТАР



О.ЦОГТГЭРЭЛ



Б.ПҮРЭВДОРЖ

Ш.РАДНААСЭД



Ц.СЭРГЭЛЭН

Т.ЭНХТҮВШИН